“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 11 ДҮГЭЭР АНГИЙН

МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

А ХУВИЛБАР **нийт 40 оноо** **Хугацаа: 60 минут**

Газрын юм

Хүнийг хоёр ээжтэй гэвэл нэг нь хойд эх юм уу өргөж авсан ээж нь юм байх гэж бодогддог. Гэтэл энэ хорвоод төрж мэндэлсэн хэн гуай ч гэсэн хоёр ээжтэй нь гарцаагүй болно. Нэг дэх ээж нь тээж төрүүлсэн ээж. Түүнтэй маргах хэн ч үгүй. Хоёр дахь ээж нь газар юм гэвэл төрөхөд эх барьж авсан “газар ээжийг” хэлж байна хэмээн бодох биз. Гэвч биш. Жинхэнэ хөрс шороот газрыг хүний хоёр дахь ээж гэж хэлэх санаатай байгааг маань болгооно буй заа. Яагаад хүн бүрийн хоёр дахь ээж хэн бэ гэвэл:

Нэг. Газрын шүүсийг ууж хүн хүн болдог /ус уухаас эхлээд/

Хоёр. Газрын шимийг хүртэж хүн хүн болдог /талх идэхээс эхлээд/

Гурав. Газрын гүйдлийг дагаж хүн хүн болдог /цахилгаан соронзон орон зайд/

Дөрөв. Газрын татах хүчийг түшиж хүн хүн болдог /хөдөлгөөний тэнцвэр олж гүйх харайхаас эхлээд/

Тав. Газрын амьсгааг шүтэж хүн хүн болдог /цаг уурын эрхшээлээс эхлээд/

Зургаа. Газрын хишгийг авч хүн хүн болдог /мөөг жимснээс эхлээд алт, мөнгө, зэс, төмөр хүртэл/

Газраас юм авахгүйгээр хүн хүн болохгүй нь бичигдээгүй хууль. Газар бидэнд бүхнийг өгнө. Тэр ч байтугай сэтгэл санаа, зан суртахууныг өгнө. Уулын хүн урт настай ч цочмог зантай байх. Тал газрын хүн тайван уужим зантай ч идэвх дутмаг байх. Ойн иргэд зоригтой ч хардамтгай байх... гэхчлэн хүрээлэн буй орчноос юу эсийг хүн олж авдаг гэх вэ? Сайнаас гадна саарыг ч авч мэднэ. Газар усны хорлол болно, лус хилэгнүүлчих нь гэж өвгөд дээдэс маань залгамжлуулан захиж гэрээсэлсэн нь учиртай. Гар дээр юм гарчихвал газрын юм гэж ярьдаг нь ч дэмий үг биш. Газарт шүтэж амьд явдаг нь ганц хүн биш. Газарт бүхий л төрлийн амьд амьтан бүгж, орогнож амьдарна. Газарт шороон түмэн нян хорхойноос эхлээд үлэмж биетэн ч шүглэсэн байдаг. Газраас цахилгаан болон соронзон гүйдэл, цацраг туяа хүртэл түгдэг. Газрын илч гэж буй. Газрын жавар ч гэж бас бий. Тэр бүхэн нь хүнд нөлөөлж насан туршид нь дагалдана.

Дэлхийн соронзон мандлын хувирал өөрчлөлт нь гол төлөв нарны идэвхжилээс шалтгаалдаг. Дэлхийн соронзон шуурга нь 27 өдөрт нэг давтагддаг нь нарны “уур хилэнтэй” давхацдаг билээ. Түүний нөлөөгөөр амьдын хорвоод уур уцаар, үхэл хагацал, осол аваар, эрсдэл гардаг. Хүний бие махбодын мэдрэхүйн босго нь эрчим хүчний 10-12 эрс /см/ хэмжээт нягтрал, гүйдэл хүчдэлийн 10-9 эрс /э.см/ хэмжээт урсгал нь хүний эс тус бүрд оногдох байдалд туйлдаа хүрдэг ажээ. Түүнээс хэтэрвээс ачааллаа даахад хэцүү болдог.

Геосоронзон талбайн нөлөө нь:

a. Оюун мэдрэлийн үйл ажиллага
b. Уран бүтээлийн үйл ажиллагаа
c. Идэвхтэй гацанги сэтгэлгээнд тус тус хүчтэй тусдаг юм байна.

Дээр дурдсан гурван хэв шинжид гео соронзон хүчдэл нөлөөлөхдөө хүний үр тогтох үед д ямархуу хэмжээний гео соронзон гүйдэл үелзэж байсан тэр л хэрээрээ тусна. Соронзон гүйдлийн нөлөө нь хүний арьснаас эхлээд цусанд хүртэл гүнзгий хамаардаг үзэгдэл.

Цусанд нөлөөлөхдөө өтгөрөх зүг рүү татдаг тул цус харвах, өсөлт болоод бэлгийн хөгжилд тусахдаа өндөр чацтай болох, эрт оворжиход хүргэх бөгөөд эмэгтэй хүний тухайд үр зулбах, сарын тэмдэг цагаас өмнө үзэгдэх зэргээр илэрдэг нь соронзон үелзлийн нэгэнт илэрхий болсон нөлөө юм.

Тэрчлэнгээр өвс ургамалд болон адгуусан амьтдад соронзон талбайн нөлөө маш нарийн хэмжүүрээр тодорхойлогддог ажээ. Нөгөөтэйгүүр, соронзон гажиг бүхий газар орон нь тэнд аж төрдөг хүмүүс болон ургамал амьтдад сайн болоод саар нөлөөтэй байдгийг нэгэнт шинжлэн судалсан ажээ.

Ямар ч байлаа гэсэн газрын соронзон мандал нь зөвхөн газраас өөрөөс нь хамааралтайгаар барахгүй сансрын жолоодлоготой нарийн тогтолцоо юм. Хүн гэдэг түүний үл ойлгогдох , басхүү үл захирагдах нууцгай эргүүлэг дунд төрж өсөөд, өтөлж өнгөрдөг болохоор хүрээлэн буй үл үзэгдэх тэр хүчин зүйлийг танин мэдэж зохилдон аж төрөх нь өлзийтэй шийдэл болох билээ.

1. “Газар усны хорлол болно, лус хилэгнүүлчих нь гэж өвгөд дээдэс маань залгамжлуулан захиж гэрээсэлсэн нь учиртай.” гэсэн өгүүлбэрийг гишүүдээр зурж, бүтцийг тодорхойл. 4оноо

   .....

   .....

   .....

2. Дараах үгсийн утгыг тайлбарлана уу. 4 оноо

   А. хишиг……

   гүйдэл …….

3. . “Эх нутаг **гэж** байхгүй байсан бол амиа өгөх юм надад байхгүй байх байсан.” Гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн утгыг олоорой. 4 оноо

А. ялган дуудах B. салган онцлох C. төсөөлөн барагцаалах D. дурсан дурдах E. батлах

4.Дараах үгсээс буруу бичсэн үгийг ол. 2 оноо

А.идшиллээ B.нарлалаа C.тэглэлээ D. нууцаллаа

5. “насал-“ хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой.

А. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад эгшгийг хойно нь бичнэ.

B. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад эгшгийг өмнө нь бичнэ.

C. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.

D. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.

E. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад шууд бичнэ.

6. Д.Нацагдорж “Ламбугайн нулимс” зохиолын гэвш Лодонг дүрсэлснийг олоорой. (2оноо)

A. Цагаан харыг гялбалзуулсаар
B. Цонхны булан дор нэгэн бяцхан нүхийг гаргасан
C. Баруун дамнуурчны шавартай гудамжнаас гарч ирэхүй нь
D. тэр үнэхээр нэг номхон хувраг, сэтгэл зөөлөн, чанар хөнгөн

7.Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. /5 оноо /

1. өгүүллэг	a/ Сонет
2. тууж	b/ Игорын хорооны үг
3. жүжиг	c/ Сүүлчийн хичээл
4. тууль	d/ Эдип хаан
5. яруу найраг	f/ Эцэг Горио

8.Оноре дө Бальзак “Эцэг Горио” туужийн дараах хэсэг ямар хам сэдэвт хамаарах вэ?

“Тэрэгний түржигнэх чимээ чийртэй, байшингууд нь харахад гунигтай бөгөөд бөглүү, баргар өнгийн хана туурга нь гяндангийн байдлыг санагдуулна.” /2 оноо /

A. Түүхийн хам сэдэв B. Улс төрийн хам сэдэв C. Шашны хам сэдэв D. Нийгмийн хам сэдэв

9**. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5 7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]**



10. “Эцэг өвгөд маань сайхан юм үзэж, сайн юм сонсож, ариун үйл бүтээж явахыг урт наслахын үндэс гэж үздэг.” Өгүүлбэрийг дэлгэрүүлэн эх зохион найруулж бичээрэй үгийн тоо 180 -200 /10 оноо /

……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 11 ДҮГЭЭР АНГИЙН

МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

В ХУВИЛБАР **нийт 40 оноо** **Хугацаа: 60 минут**

Архангайн замд

1976 оны бороо ногоо тэгш сайхан зун С. Эрдэнэ тэргүүтэй хэдэн зохиолч уул даваа, ус гол гаталсан урт зам туулж, Архангайн Хорго, Тариат хүрлээ. Шөнө нь бороо орж, өдөр нь нар гарч, цаг агаар тусгай хөтөлбөртэй мэт байв. Гол усны хөвөөн дээр майхнаа барин, хээр хөдөө унтаж, өглөө нь машиндаа ачаалан, аян замдаа гарна.

Нэг өдөр бид хэд Хоргын тогооны ирмэг дээр зогсож байлаа. Гүн ёроолдоо хар ногоон устай энэ ”тогоо”-г хадан ирмэг дээрээс нь харахад аймаар, хөл алдвал дууслаа гэж бодсон сон.

Хорго үзсэний дараа С. Эрдэнэ нэг орой ”Би нэг шуналтай хүний тухай бичих санаа оллоо. Хомхой шуналаасаа болоод галт уулын тогоо руу орчихсон хүний тухай “Занга” богино өгүүллэг бичье” гэж тэр дороо л шинэ санаа олж бидэнд ярив.

Хорго, Тариатын нутгаас буцаж явахдаа бид Суман гол, Чулуут голын бэлчир дээр хүрч ирлээ. Хоёр ширүүн гол хар эрчээрээ явж, нэгэн хавцалд уулздаг аж. Зохиолч С. Эрдэнэ үүнийг “Цагаан устай Чулуут, хар устай Суман, хадан цээжтэй хатуу газрыг хага цохин нийлжээ. Нийлэх гэж тэмүүлэн тэмүүлсээр үүрд салшгүй нийлжээ. Чулуут, Суман хоёр эвлэрэн нийлэх гэж үзэлцсэн нь үнэхээр залуу хар эрээн барс, цагаан арслан хоёр уулнаас үсрэн бууж ноцолдон байх мэт” гэж уран сайхан дүрээр буулган хэлж байлаа.

Би Суман голыг хараад:

- Аргагүй жавхлантай гол юм гэсэнд С.Эрдэнэ:

- Юу гэнээ хө гэв. Би дахин:

- Жавхлантай гол юм аа гэвэл,

- Үүнийг чинь юманд оруулна даа хө гэж хэлж байна. Тэгээд “Долгорын Нямаа Суман голыг жавхлант гол гэж яруу найрагчийн ёсоор онож хэллээ” гэж надад урам өглөө. Ийм маягаар оносон нэг үгэнд ч олзуурхаж явдаг нь нарийн гярхай нүдтэй бичгийн хүний төрх араншин мөн ажээ.

Долгорын Нямаа

1. “С.Эрдэнэ тэргүүтэй хэдэн зохиолч уул даваа, ус гол гатлан, урт зам туулж, Архангайн Хорго, Тариат хүрлээ” гэсэн нийлмэл өгүүлбэрийг зөв тодорхойлоорой. **/4 оноо /**

A. Угсарсан нийлмэл өгүүлбэр B.Харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

C. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр D, Холимог нийлмэл өгүүлбэр

2. Ойролцоо утгатай хэлц бүхий хэсгийг сонгоорой. /4 оноо\

A. хараа цуцам - тохмын чинээ B. алга дарам - далан хэлийн

C. аргамжаатай явах - хэрэн хэсэх D. хараа цуцам - хязгаар хярхаггүй

3 .“Хичээлээ сайн уншаагүй**<u>гээс</u>** шалгалтандаа тааруу дүн авлаа” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийг ойролцоо утгатай холбоос үгээр солин найруулаарай. **/4 оноо /**

A. Учраас B. Буюу C. Үед D. Тулд

4.Залгавар залгахад “ь” нь “и” болох үгийг олно уу. **/2 оноо /**

A. тарь+даг B. тань + ж C. горьгүй D. дохь + цгоо

5. Бүгдийг зөв бичсэн хэсэг аль вэ? **/2 оноо /**

A. бодохоор, мангарыг, Завхнаас B. авгын, үзэхээр, төмрийн

C. хургыг, үхрын, үнэний D.очхоор, босход, дуусхаар

6. Игорийн хорооны үг" зохиолын дараах хэсгийн дүрслэх ур маягийг тодорхойлоорой. **2 оноо /**

"Байлдааны бэлэн дуунаар

Манцуйлуулж,

Баатар дуулган доор

Бүүвэйлүүлж,

Жадны үзүүрээр угжуулсан,

Жавхлант баатар эрс болсон юм."

a. Төлөөлөл в. Ёгтлол c. Ихэсгэл d. Адилтгал

7. "Амраг хонгороосоо олон сар хагацан уйдаж суусаар турж,

Алтан бугуйвч царвуунд тогтохгүй

Бүрвасад сар төгсөх өдөр

Аугаа заан, соёогоор уул мөргөн наадах мэт бөхийсөн

Алсын үүл, уулын оргилд налан наалдсаныг ажин үзвэй"

"Үүлэн зардас" найраглалын энэхүү хэсэг нь зохиолын ..... юм. **2 оноо /**

A. Зангилаа B. Эхлэл C. Өрнөл D. Туйл

8. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. **/5 оноо /**

1.өгүүллэг	a/ Сонет
2.тууж	b/ Игорын хорооны үг
3. жүжиг	c/ Сүүлчийн хичээл
4.тууль	d/ Эдип хаан
5. яруу найраг	f/ Эцэг Горио

9. **Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно.**

ᠬᠥᠪᠦᠨᠳᠡᠭᠡᠨ ᠳᠤᠷᠠᠯᠳᠠᠨ ᠪᠠᠶᠢᠴᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠪᠣᠯᠣᠨ ᠳᠤᠷᠠᠯᠳᠠᠨ ᠪᠣᠯᠣᠨ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡᠭᠡᠨ ᠳᠤ ᠪᠣᠯᠣᠨ ᠳᠤᠷᠠᠯᠳᠠᠨ ᠪᠣᠯᠣᠨ ᠴᠠᠭᠠᠨ ᠳᠤᠷᠠᠯᠳᠠᠨ ᠪᠣᠯᠣᠨ ᠴᠠᠭᠠᠨ ᠳᠤᠷᠠᠯᠳᠠᠨ ᠪᠣᠯᠣᠨ ᠬᠠᠷᠠᠭᠤᠯᠠᠭᠳᠠᠨ ᠳᠤᠷᠠᠯᠳᠠᠨ ᠪᠣᠯᠣᠨ ᠬᠣᠭᠣᠨᠳᠤ

10**. “Бороо” сэдвээр 150 үгтэй эх зохиож бичихдээ баримт, тайлбар ашиглан, орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй. \10 оноо**

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 11 ДҮГЭЭР АНГИЙН

МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

С ХУВИЛБАР **нийт 40 оноо** **Хугацаа: 60 минут**

Нэгдүгээр хэсэг: Эхийг уншиж ойлгоод, дасгал, даалгаврыг гүйцэтгээрэй.

Дэлхий хэмээх энэ агуу том бөмбөрцөг мөхөл рүүгээ цаг минутаар урагшилж байна. Эрдэмтэн судлаачид ийм дүгнэлтэд хүрч, өдөр тутмын аар саархан зүйлийн араас хөөцөлдөн хоногийн бор хоолоо бодон амьдарч буй хүмүүсээс илүүтэй санаа зовних болов. Манай гараг түүхэндээ бишгүй олон осол гамшигтай учирч, амьтан бүхэн устан үгүйрч байлаа. Дэлхийн сүйрлийн тухай домог үлгэрүүд олон зууныг дамжин өртөөлсөөр бидэнд өвлөгдөн үлджээ. Ялангуяа хамгийн аймшигт сүйрлийн үеэр устсан дөрөв дэх соёл иргэншлийн талаар маш олон баримт нотолгоо ар араасаа хөврөн гарсаар л байна. Атлантид гүрний мөхөл бол тэдгээр соёл иргэншилт нийгмийн тод жишээ юм. Эрдэмтэд дэлхийг сүйрүүлэх долоон шалтгааныг нэрлэж байна.

Соронзон туйл өөрчлөгдвөл...

Өнгөрсөн зургаан тэрбум жилийн хугацаанд дэлхийн соронзон туйл байрлалаа хэдэн зуун удаа өөрчилснөөс болж уур амьсгал нь огцом хувирч байжээ. Тухайлбал: 12 мянган жилийн өмнө дэлхий мөсөнд хучигдан үй олон амьтад үхэж үрэгджээ. Үүнийг геофизикчид туйлын байрлал өөрчлөгдсөнтэй холбон тайлбарладаг.

Тэд туйлын “суудал”-аа өөрчилсөн газраас 2000 км орчим яваад буцаж ирэхдээ энэхүү дүгнэлтийг гаргасан байна. Соронзон туйл эдүгээ өөрчлөгдөх замдаа аль эрт шуудран орчхоод байгаа аж. Америкийн цэрэг, техникийн их сургуулийн тооцоолсноор, дэлхийн хойд соронзон туйл өнгөрсөн арван жилийн хугацаанд хэдэн зуун метрээр өөрчлөгджээ. Магадгүй хамгийн сүүлийн, хамгийн томоохон “нүүдэл” энэ зууны төгсгөлд болж мэдэхээр байна.

“Тэр үед хүн төрөлхтөн болоод ан амьтан, хөвч ой, ургамал ногооны дийлэнх хэсэг нь устана” хэмээн Шмидтийн нэрэмжит дэлхийн физик судлалийн төвийн орлогч захирал Алексей Диденко ярьжээ. Гэхдээ түүний үгээр бол туйлын энэхүү өөрчлөлтийн улмаас соронзон талбайн хэмжээ багасан, дэлхийн гадаргуу нарны хэт цацрагийн хорт нөлөөнөөс хамгаалагдах талтай гэнэ.

Г. Идэрхангай “Дэлхийн төгсгөлийн 7 шалтгаан” өгүүллээс хэсэглэж авав.

Дараах өгүүлбэрийн бүтцийг тодорхойлоорой. \4 оноо

1.“Анимаагийн гунигаар өвс бүхэн шаргалтаж, гол ус зайрмагтан, тунгалаг сэтгэлийн нулимс адил жирэлзэн урсаж, нимгэн мөсөн доогуур мэлмэрнэ..”

A. Хэлэх аялгаар холбогдсон зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр B.Угсарсан нийлмэл өгүүлбэр

C. Холимог нийлмэл өгүүлэбэр D. Зэрэгцүүлэн холбох нөхцөлөөр холбогдсон ЗНӨ

2.Эхэд орсон нийлмэл үгсийн дарааллыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг нь олоорой. 4оноо

“Аар саархан, соронзон туйл, осол гамшиг, дэлхийн гадаргуу, ан амьтан, ... “

А.соронзон талбай Б.баримт нотолгоо В.санаа зовних Г. хүн төрөлхтөн

3**. Өгүүлбэрт онцолсон бүтээврийг солин найруулахад тохирохыг сонгоорой. /2 оноо**

*IАнимаагийн гунигаар өвс бүхэн шаргалтаж, гол ус зайрмагта**н**, тунгалаг сэтгэлийн нулимс адил жирэлзэн урсаж, нимгэн мөсөн доогуур мэлмэрнэ.*

A. –ж, B. –на C. –маар D. –сан

“агаад, хийгээд, буюу, бөгөөд” зэрэг бүтээврүүдийн утга, үүргийг тайлбарлаарай. /2 оноо /

А.Угсруулан холбох В.Зэрэгцүүлэн холбох С.Шалтгааны утгаар холбох D.Цагийн утгаар холбох

4.Дараах үгсээс буруу бичсэн үгийг ол. /2 оноо /

А.идшиллээ В.нарлалаа С.тэглэлээ D. нууцаллаа

5. **Буруу бичсэн бүлэг үгийг олоорой.**

А. орчихоод, эргэчихбэл, тугаллаа В. биччихийг, туслахаар, төрөлхтнөөр

С. иулгамдсанаас, шагалзахыг, үзьюү D. бузардсанаар, олонхи, хуулчхыг

Е. баримтнаас, хэвлэгдсэнийг, урсжээ

6. Амель гэж ямар зохиолын дүр вэ?

А.Эцэг Горио Б.Махабхарата В.Сүүлчийн хичээл Г.Сүүлчийн даалгавар

7. “Сүүлчийн хичээл” өгүүллэгийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг сонгоорой./2оноо /

А. Сүүлчийн хичээлийг сурагчийн болоод багшийн сэтгэлд хоногштол заадаг.

В. Аливаа улс орныг устгахын тулд хэл соёлыг нь хааж боодог.

С. Герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн учраас сүүлчийн хичээлийг зааж байна.

D.Франц хэлний хичээлийг үзэж дуусаж байгаа болохоор сүүлчийн хичээлийг орсон.

8. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. /5 оноо /

1.өгүүллэг	a/ Сонет
2.тууж	b/ Игорын хорооны үг
3. жүжиг	c/ Сүүлчийн хичээл
4.тууль	d/ Эдип хаан
5. яруу найраг	f/ Эцэг Горио

9. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]



10. Дараах сэдвээр эх зохион бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 100-150/ [10 оноо] **"Би Монгол хүн"**

……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 11 ДҮГЭЭР АНГИЙН

МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

D ХУВИЛБАР нийт 40 оноо Хугацаа: 60 минут

Мэргэний хөндийд дөрвөн цаг эгшиглэнэ

Мэргэний хөндий, миний төрж өссөн нутгийн минь олон хөндийн нэг дээ. Энэ хөндийд элэнц хуланцаас минь эхлээд өдгөө миний энэ үе хүртэл өвгөд хөгшид минь адуу малаа адгуулж, нүүж сууж, жилийн дөрвөн улирлыг жирмийн сүлжээ шиг сүлжиж, жаргал зовлон, инээд гуниг ээлжилсэн амьдралаа бүтээж ирсэн юм. Мэргэний хөндийд л дөрвөн цаг дөрвөн цагаараа эгшиглэдэг. Өвөл гэмээ нь хамгийн хатуу ширүүн болдог. Анхны орсон цас хэзээ ч зогсохгүй бударсаар бударсаар энэ хөндийг нэлд нь бүрхэнэ. Өвлийн цагт атан тэмээгээр л жонжуулж туулна уу гэхээс өөр унаа малаар бүтэшгүй, чухам л цагаан далай гээч нь болно шүү дээ.

Мэргэний хөндийд үүл уначихжээ гэсэн үгийг хэн нь ч анх хэлсэн юм, түүнээс хойш юм л бол өвлийг “Мэргэний хөндийд үүл уначихжээ...” гэж энэ нутгийнхан тодорхойлсоор билээ. Гэхдээ бас хамгийн баяртай, гэрэлтэй сайхан үг ч Мэргэний хөндийтэй холбоотойгоор хэлэгддэг. Мэргэний хөндийн цас хамгийн түрүүнд сэмэрч, түүний элгэн доороос яргуй цэцэг хамгийн түрүүнд нүдэлнэ. Энэ үед нутгийн ардууд “Мэргэний хөндийд яргуй нүдэлжээ...” гэцгээх нь бий... Энэ бол хавар иржээ гэсэн үг юм. Тийнхүү Мэргэний хөндийд хамгийн түрүүнд ногоо соёолж, зуны өмсгөлөө байгаль дэлхий энэ хөндийд л өмсөнө шүү дээ.Холын уулс ч Мэргэний хөндийг л дуурайж ногоорно. Түүнчлэн Мэргэний хөндийн намар бүр ч гоёхон доо. Бугын зоо шиг халиурч, үнэгний сор шиг гялталзана. Өвс ногоо чухам яахаараа тэгж шим шүлтээ гүйцэд авч шаргалтана вэ? Хялгана чухам яахаараа тэгж далайн давлагаа шиг үелзэн гүвэлзэн долгилно вэ? Салхин хэрхэн, юунд саатна вэ? Мэргэний хөндийд тэнгэр ширтэн хэвтэхэд юу эс бодогдох билээ...

Хэдэн мянганы турш Мэргэний хөндийд эцэг дээдэс минь нутаглаж, он жил нисэн нисэн ирж, он жил нисэн нисэн буцжээ. Энэ талд хэзээ нэгтээ хөх тэнгэрийн солир харван унаж, тэрчлэн энэ талаас бас өвгөд хөгшид минь тэнгэрийн уудамд хүсэл бодлоо бэлчээн залбирч зогссон байж таарна. Чингисийн морьтон баатрууд хүлгийн туурайгаараа тамгалж, Сүх жанжны журамт дайчин эрс уухайн дуу хадааж, монгол жинчин идэр есийн хүйтнээр хөөглөж, эрийн гурван наадмаар хурц дөмөн морьд хүүхдийн гийнгоонд уярч байсан биз ээ. Мэргэний хөндий минь мэргэн хөндий. Мэргэнд нь эх орон минь өөдөлж, үр ач нар минь дэвшин дээшилж, хүссэн бүхэн нь биелж, аз жаргалтай амьдрахын гэгээн төлөг буусан бий. Д.Нямаа

1. **"Мэргэний хөндийн цас хамгийн түрүүнд сэмэрч, түүний элгэн доороос яргуй цэцэг хамгийн түрүүнд нудэлнэ гэсэн нийлмэл өгуулбэрийг энгийн өгүүлбэр болгон зөв задалсан хэсгийг олоорой. /4 оноо /**
   A. Мэргэний хөндийн цас хамгийн түрүүнд сэмэрнэ. Түүний элгэн доороос яргуй хамгиин түрүүнд нудэлнэ.
   B. Мэргэний хөндийн цас хамгийн түрүүнд сэмэрнэ. Цасны элгэн доороос яргуй хамгиин түрүүнд нүдэлнэ.
   C. Мэргэний хөндийн цас сэмэрнэ. Яргуй хамгийн түрүүнд нудэлнэ.
   D. Мэргэний хөндийн цас хамгийн түрүүнд сэмэрнэ. Яргуй нудэлнэ.

E.

2. **Үйл үгийн угсруулан холбох нөхцөлөөр бүтсэн хэсгийг олж тэмдэглээрэй./2**

A. терж ессен нутаг, уелзэн долгилно, нисэн ирнэ, Мэргэний хендий

B. нисэн ирнэ, 6элчээн залбирна, жонжуулж туулна, бударсаар бqрхэнэ

C. жаргал зовлон, инээд гуниг, гэрэлтэй сайхан, он жил, вввг **дээдэс**

D. очилгуй болохгуй, сонсвол дуулгаарай, хийнгээ бодох, хурмэгц дуусна

Эсрэг утгат бүтээвэр бүхий хэсгийг сонгоорой. /2 оноо /

A. тохь + той, тохь + гүй B. нимгэн + л, нимгэн + д C. танай + хан, танай + х

D. гэд + лз, гэд + ий

3. **Залгавар залгахад "ь" нь "и" болохгүй үгийг олоорой. /2 оноо /**

A. сахь + ж B. барь + жээ C. соль + могц

D. зохь + дог E. холь + оо

4. **Бүгдийг зөв бичсэн хэсэг аль вэ? /2 оноо /**

A. бодохоор, мангарыг, Завхнаас B. авгын, үзэхээр, төмрийн

C. хургыг, үхрын, үнэний D.очхоор, босход, дуусхаар

5. **Эсрэг утгат бүтээвэр бүхий хэсгийг олоорой. /2 оноо /**

A. уйл + хай, уйл + нхай B. ач + тан, ач + тай C. ов + ой, ов + н D. илч + тэй, илч + гүй

6. Галидас "Үүлэн зардас" зохиолоос авсан эшлэлүүд зохиолчийн ямар мэдрэмжээс үүдэн гарсан бэ? /2оноо /

1. "Зааны бохь анхилж, замбу модод мөргөлөн урсагч, Нармада голын сайхан уснаас сэрүүцэн сэргэж уу.

2. Үнэр хөлөглөгч орсон хулсны яруу аялгуу гараад Гинарын хатагтай нар хөгжмийн аялгуу нийлүүлэн...

3. Царайны өнгөө лодрэ цэцгийн оо түрхэж цайвар болгоод Гүрвага цэцгээр үсээ, сайхан шриша цэцгээр чихээ чимээд

4. Видиша хэмээн хотол алдаршсан Дасарнын нийслэл хүрээд Видравадын мяралзсан долгионт уснаас үнсэн цэнгэхэд

A.Харах мэдрэмжээс B.Үнэрлэх мэдрэмжээс C.Амтлах мэдрэмжээс D.Сонсох мэдрэмжээс

А.1c 2a 3b 4d Б.1a 2b 3d 4c В.1b 2d 3a 4c Г.1b 2c 3a 4d Е 1b,2a,3d,4c

7. Эмгэнэлт жүжгийн гол баатрын шинжийг илэрхийлсэн онолын зөв тодорхойлолтыг сонгоно уу? /2оноо /

А.Эр зоригтой, энэрэнгүй, өөрийнхөө мөн чанарыг олсон хүн

Б.Хүний хамгийн төгс сайхан шинжийг өөртөө шингээсэн, зохиолын төгсгөлд бусдын сайн сайхны төлөө тэмцсээр байгаад амь эрсэддэг хүн В.Бусдын төлөө тэмцдэг баатарлаг хүн

Г.Уншигчдад хайр харууслыг үлдээж чаддаг, хүний сайхан чанаруудыг өөртөө шингээсэн хүн

8. **Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. /5 оноо /**

1.өгүүллэг a/ Сонет

2.тууж b/ Игорын хорооны үг

3. жүжиг c/ Сүүлчийн хичээл

4.тууль d/ Эдип хаан

5. яруу найраг f/ Эцэг Горио

9. **Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно.**



10. Өгөгдсөн хэсгийн гол санааг хадгалан түүнийг нэмэн дэлгэрүүлж, эх зохион бичнэ үү.

Бүтээлчээр ургуулан бодож бичихдээ аль болох оновчтой үг хэллэг, уран яруу дүрслэл, баримт мэдээлэл ашиглаж, найруулга зүйн шаардлагыг ханган бичихийг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 100 -150/ [10 оноо]

Бүргэд хүртэл дэгдээхийгээ газарт буулгалгүй улам өндөр авхуулан хөөргөж, бүр эцэж цуцтал нь нисгэж сургадаг.

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

……

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 11 ДҮГЭЭР АНГИЙН

МОНГОЛ ХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Е ХУВИЛБАР **нийт 40 оноо** **Хугацаа: 60 минут**

Мөсөн зам

Нэгэн чулуун арслан амьд юм шиг алгуурхан урагшилна. Гэнэт харсан хүн цочмоор.... Сайн ажиглавал хэн нэгэн наана цаана нь гарч нарийн урт модоор хөшүүрэгдэх нь циркчиний үзүүлбэр гэлтэй. Чулуучин ууланд урлан сийлсэн арслангаа эх хаднаас нь тасдаж аваад бэл рүү буулгаж яваа нь энэ аж. Хөөрхий урлаачийг дээдсийн зарлигийг биелүүлэхэд нь ус л ганц сайн туслагч нь болжээ.

Арслангаас бэл хүртэл бэлээс хийд хүртэл зассан мөсөн зам нарны гэрэлд гялбалзан үзэгдэнэ. Энэ мөсөн зам дагуу хошууны эрх бариачингууд ямбалан явж үзэж сонирхоцгооно. Ард нийтэд харуулах нь зохисгүй гэж лүндэгнэсэн болохоор энд хэн ч үл үзэгдэнэ. Тэд урлаачийн нарийн ухааныг өвөр зуураа шагшина. Дээдэст таалал олох үйлс нь бүтэмжтэйд хөөрцөглөн буй нь илт. Урлаач чулуун арслантайгаа л хөөрөлдөн ягуухан урагшилна. Тэр хоёр магадгүй дөрвөн улирлын турш нөхөрлөсөн болохоор ийн дотносох нь зүйн хэрэг.

“Хүний мөсөөр хэрэв зам засаж болдог сон бол энэ дэлхийн бөмбөрцгөө бүслүүрдэн ороосон зам тавих сан. Тэгээд тэр замаараа муу ээжийгээ арган дээр суулгачхаад гулгуулан явж олон газар орныг үзүүлэх сэн. Ээж минь яасан их баярлах бол… Гэтэл манай хошууныхны хүний мөс дэлхийг ороож хүрэх болов уу. Юу л бол...” Урлаач чулуун арслантайгаа ийн хөөрнө.

Арслан дув дуугүй өмнөх замаа л ширтэнэ. Тэгэвч урлаачийн хүүрнэлд хөхин баяссан мэт үе үе хурдаа нэмнэ. Урлаач өөрийн эрхгүй инээмсэглэнэ. Ядрал зүдрэл нь сарнин одно. Сүмийн бараа ойртоно. Сүмийн дэргэд ээж үзэгдэнэ.

1.“Чулуучин ууланд нь урлан сийлсэн арслангаа эх хаднаас нь тасдаж аваад бэл рүү нь буулгаж яваа нь энэ аж.” гэсэн ХоНӨ дэх арслан гэдэг үгийг тодотгон дэлгэрүүлсэн гишүүн өгүүлбэрийг олоорой. 4оноо

A. Чулуучин эх хаднаас нь салгаж аваад.
B. Чулуучин бэл рүү нь буулгаж яваа
C. Чулуучин буулгаж яваа нь энэ аж.
D. Чулуучин арслангаа буулгаж аваад
E. Чулуучин урлан сийлсэн

2. **Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой. /4оноо /**

1. алгуурхан	a. олноороо магтах
2. ямбалан	b. аажим удаавтар явах
3. лүндэн	c. эрх ямбыг эрхэмлэн суух
4. хөөрцөглөх	d. зарлиг заавар, эш бошго буулгах
5. шагших	e. хөл хөөр болох, баярлах

A. 1b, 2e, 3d, 4e, 5a B. 1b, 2c, 3d, 4e, 5a C. 1a, 2c, 3d, 4e, 5d
D. 1c, 2a, 3d, 4e, 5b E. 1d, 2c, 3b, 4e, 5a

3. **“улирлын турш” холбоо үгийн “-ын” бүтээвэр нь ямар утга ялгаж байгааг олоорой. 4оноо**

A. орны B. цагийн C. эзэмшлийн D. зориулалтын E. бүхлийн

4. Залгавар залгахад “ь” нь “и” болохгүй үгийг олоорой. /2 оноо /

A. сахь + ж B. барь + жээ C. соль + могц D. зохь + дог E. холь + оо

5. **Бүгдийг зөв бичсэн хэсэг аль вэ? /2 оноо /**

A. бодохоор, мангарыг, Завхнаас

B. авгын, үзэхээр, төмрийн

C. хургыг, үхрын, үнэний

D.очхоор, босход, дуусхаар

6. Эхийн “Бугын зоо шиг хариурч, үнэгний сор шиг гялтганана. Өвс ногоо чухам яахаараа тэгж шим шүлтээ гүйцэд авч шаргалтана вэ? Хялгана чухам яахаараа тэгж далайн давлагаа шиг үелзэн гүвэлзэн долгилно вэ? гэсэн хэсэгт уран дүрслэлийн ямар аргыг түлхүү хэрэглэн бичсэн байгааг тодорхойлоорой. /2 оноо /

A. ахиулал B. ихэсгэл C. адилтгал D. төлөөлөл

7. “ .... орогшинхул мориныхоо согсоо гөхлийг ширтэн гэлдрүүлж явна. Тэр мунхаг ядуу гэж урагт үл тооцогдон ах нартаа адлагдан хөөгдсөндөө нэг их гутарсан ч үгүй. Харин ч ухаан тэлүүлж, нэгийг бодон хоёрыг эргэцүүлэх хугацаатай боллоо гэж тайвширна. Олон сүргийн дундаас зүс буруу гэх энэ муу гол дайрт годил сүүлт орогшинхул морийг надад ах нар минь өгсөн юм.” Гэж ямар зохиолд хэнийг дүрсэлсэн бэ? **/2 оноо /**

A. Ж.Саруулбуян “Бодончар Богд” егууллэгийн Бодончарын дүр

B. "Жамухын өчил“ егууллэгийн Жамухын дүр

C. МНТ зохиол дахь Бодончарын дүр

D. МНТ зохиол дахь Жамухын дүр

8. **Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. /5 оноо /**

1.өгүүллэг	a/ Сонет
2.тууж	b/ Игорын хорооны үг
3. жүжиг	c/ Сүүлчийн хичээл
4.тууль	d/ Эдип хаан
5. яруу найраг	f/ Эцэг Горио

9. **Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]**



10 . “Сүүдэр” сэдвээр эх зохион бичээрэй. Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 100-150/ [10 оноо]

……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……
……